

Агуулга

Бүлэг 1. “Идэр Хайрхан” ХХК-н товч танилцуулга.....	3
1.1. “Идэр Хайрхан”ХХК-н үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал	
1.2. “Идэр Хайрхан”ХХК-н түүхэн товчоон.....	4
1.3. “Идэр Хайрхан”ХХК-н компаний зорилго.....	
1.4. Уулын ажлын төлөвлөгөөний товч.....	5
1.5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухай жилийн гол зорилт.....	10
Бүлэг 2. Төсөл хэрэгжиж буй орон нутгийн байгал орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	12
2.1 Уул зүй.....	
2.2 Ус зүй.....	
2.3 Уур амьсгал.....	
2.4 Хөрс ургамал	
2.5 Амьтан	
2.6 Хүн амьтан эдийн засаг нөлөөлөл.....	13
Бүлэг 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	
3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг	
3.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	14
3.3 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	14
3.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл....	14
Бүлэг 4 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	
Бүлэг 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	15
5.2 Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	16
5.3 Газар, хөрсний элэгдэл, эвдрэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээ	16
5.4 Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээ	
5.5 Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	
Бүлэг 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	17
Бүлэг 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
Бүлэг 8 Түүх соёл шинжлэх ухааны дурсгалт зүйлс.....	20
Бүлэг 9. Хог хаягдал менежментийн төлөвлөгөө	20
Бүлэг 10. Орчины хяналт шинжилгээний бүртгэл	22
Бүлэг 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	
Бүлэг 13. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	
Бүлэг 14. Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөний нэгдсэн төсөв.	

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Уурхайн ажиллах горим	6
Хүснэгт 2. Уурхайн 2024 онд хуулах хөрсний тооцоо	8
Хүснэгт 3. Өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцоо	9
Хүснэгт 4. Ашиглалтын системийн үндсэн хэмжигдэхүүнүүд	10
Хүснэгт 5. Уурхайн гадаргуугийн байгууламж, эдэлбэр газрын хэмжээ	11
Хүснэгт 6. Уурхайн тоног төхөөрөмжүүдийн түлшнээс ялгарха хорт хийн хэмжээ.....	14
Хүснэгт 7. 2024 онд агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажил.	17
Хүснэгт 8. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил.....	19
Хүснэгт 9. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд.....	20
Хүснэгт 10. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
Хүснэгт 11. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах ажлууд.....	23
Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	26
Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	28
Хүснэгт 14. Уурхайгаас сард ялгарах ахуйн бохирын тооцоо.	30
Хүснэгт 15 “Тамир Эм” бэлдмэлийг хэрэглэх календарчилсан төлөвлөгөө.....	30
Хүснэгт 16. Техникийн үзүүлэлт.....	31
Хүснэгт 17. Хог хаягдлыг менежментийг төлөвлөгөө.	32
Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.	33
Хүснэгт 19 Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	34
Хүснэгт 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа.....	36
Хүснэгт 210. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	37


БҮЛЭГ 1. “ИДЭР ХАЙРХАН” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1.1 “Идэр хайрхан” ХХК-н үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Цохио толгой – 2 шохойн чулууны орд нь Дархан-Уул аймгаас зүүн тийш 6.5 км, Хонгор сумаас хойш 31 км-т Шийрийн хөндийн адагт Цохио толгойн өвөрт байрладаг.

Төслийн байршлын газар зүйн солбицол:

Зүүн уртрагийн	Хойд өргөргийн
106°02' 22”	49° 26' 05”
106°02' 22”	49° 26' 20”
106°02' 55”	49° 26' 20”
106°02' 55”	49° 26' 05”



Зураг 1.  -“Цохио толгой 2” шохойн чулууны ордын байршлын зураг

1.2 “Идэр хайрхан” ХХК-н түүхэн товчоон

Зөвлөлтийн геологичид 1962 оны 3-р сарын 26-н тайлан хамгаалж геологийн нөөцийг дараах зэрэглэрээр тогтоожээ. 1980 онд Монголын геологичид нэмэлт хайгуул хийж үлдэгдэл нөөцийг тогтоожээ.

“Идэр Хайрхан” ХХК нь “Цохио толгой – 2” нэртэй орд газар ашиглалтын 30 гектар талбайг 2007 оноос эхлэн 30 жилийн хугацаанд ашиглах 1921021009 тоот гэрчилгээтэй. Уг орд нь баруун хойноос урагш 1.4 км орчим сунасан, өргөнөөрөө 1.2 км, ойролцоогоор 1.7 кв.км талбайг эзлэн тогтсон байна. Газрын гадаргуугийн өндөржилт 1170-аас 1230 м хооронд өргөгдсөн байна. Уг чулуулаг нь цагаан өнгөтэй, дунд зэргийн ширхэгтэй, нягт хатуу, нэг төрлийн найрлагатай. Карбонат чулуулаг нь моноклинал байрлалтай, суналын өнцөг нь 45° -аас 70° -аар сунасан. Чулуулгын ерөнхий сунал нь баруун урдаас зүүн хойш 40° - 70° сунасан.

Нөөцийг ашиглахдаа порфир судлаас ялган тодорхойлж тэсэлгээ хийх ба 100м радиусаар 5-10м мөрөгцөгөөр шалан ашиглалт хийхээр төлөвлөсөн. 4м гүнтэй 50 цооног өрөмдөж тэсэлгээг улиралд нэгээс хоёр удаа хийдэг. Олборлосон шохойн чулууг гэрээгээр шохой цементийн үйлдвэрүүдэд нийлүүлдэг.



Зураг 2.

1.3 Төслийн зорилго:

Орд газраас шохойн чулууг олборлон хямд, сайн чанарын шохойн чулууг шохойн болон цементийн үйлдвэрүүдэд нийлүүлэх, орон нутагт тодорхой хэмжээний ажлын байр бий болгох, цаашид ордыг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах замаар ашиглалтыг нь сайжруулан ордоос олборлосон бүхнийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгож борлуулах, орд орчмын унаган төрхийг эргүүлэн сэргээх нөхөн сэргээлт хийхэд голлон анхаарах зорилт тавин ажиллаж байна.

1.4 Уулын ажлын төлөвлөгөөний товч

Цохио толгой – 2 шохойн чулууны уурхайд 2024 онд фронтын чиглэлд ахих болон ил уурхай гүнзгийрэх чиглэлд уулын ажлыг цааш нь үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөөд байна. Уурхай 45 метр гүн буюу +760м – ийн түвшин хүртэл, давхаргын суналд хөндлөн чиглэлээр уулын ажлыг явуулна. Энэ үед уурхайн урт 290м, өргөн дунджаар 160м, уурхай 3.7 га талбайг эзэлж байна /нийт уурхайлалтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд өртсөн талбай 8.6 га болж нэмэгдэнэ/. “Цохиот толгой-2” ил уурхай нь 2024 онд жилийн турш, хоногт 10 цагаар ажиллах нэг ээлжийн зохион байгуулалттай ажиллана. Энэ хугацаанд ордоос 38.5 мян.м³ хөрс хуулж, 70.0 мян.тн шохойн чулуу олборлон түүхий эд бэлтгэн борлуулахаар төлөвлөж байна.

Уурхайн ажиллах горим. “Цохиот толгой – 2” уурхайн 2024 онд гүйцэтгэх уулын ажлын хэмжээг үндэслэн жилийн турш тасралтгүй ажиллагаатайгаар ажиллахаар тооцлоо. Уурхайн ажиллах горимыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Уурхайн ажиллах горим

Сарууд	Календар хоног	Амралтын өдөр	Ажиллах хоног	Ажиллах ээлжийн тоо	Ажиллах хугацаа, цаг
1	31	8	23	1	220
2	29	8	21	1	200
3	31	10	21	1	230
4	30	8	22	1	200
5	31	8	23	1	230
6	30	10	20	1	220
7	31	13	18	1	180
8	31	9	22	1	230
9	30	9	21	1	210
10	31	8	23	1	220
11	30	9	21	1	220
12	31	9	22	1	210
Жилд	366	109	257		2570

Хөрс хуулалтын ажил. Цохио толгой – 2 уурхайн үндсэн хөрсний чулуулгийн хатуулаг нь VIII-X зэрэглэлд хамаарагдаж байгаа нь хөрсний чулуулгийг авахдаа урьдчилан өрөмдлөг-тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлт хийж шилжүүлэх шаардлагатайг харуулж байна. Хөрсний чулуулгийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлсний дараа эксковатороор автосамосвалд ачин ил уурхайн гадна байрлах гадаад овоолгын талбайд байрлуулна. Хөрс хуулалтын ажилд 1.2 м³-ын утгуурын багтаамжтай урвуу утгуурт гидравлик эксковатор

ажиллана.

Шохойн чулуу олборлолт. Шохойн чулууны олборлолтын догол нь суналын дагуу чиглэсэн ахилттай, 5м өндөртэй байна. Олборлолтонд 1.2 м^3 – ын утгуурын багтаамжтай гидравлик эксковатор ажиллана. Автосамосвалууд хөрс, хүдрийн тээвэрлэлтэнд ажиллах хосолмол ажиллагаатай байна. “Цохио толгой – 2” ордоос 2024 онд нийт 70.0 тн шохойн чулуу олборлон уурхай дээрээс шууд “Тулгат шийр” ХХК, “Сутай үхэр чулуут” ХХК - д борлуулахаар төлөвлөөд байна.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Хүснэгт 2. Уурхайн 2024 онд хуулах хөрсний тооцоо

№	Үзүүлэлтүүд		2024 онд ажиллах улирал				Нийт
			I-р улирал	II-р улирал	III-р улирал	IV-р улирал	
1	Уулын цул	мян.м ³	12.8	19.0	19.7	14.0	65.4
2	Хөрс хуулалт	мян.м ³	7.00	11.3	12.0	8.2	38.50
		мян.тн	15.4	24.8	26.4	18.1	84.7
3	Шохойн чулуу олборлолт	мян.м ³	5.8	7.7	7.7	5.8	26.92
		мян.тн	15	20	20	15	70.0
4	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³	2.67	3.22	3.43	3.14	3.15
		м ³ /тн	1.03	1.24	1.32	1.21	1.21

Өрөмдлөг – тэсэлгээний ажил.

Уурхайн хөрсний чулуулаг болон шохойн чулуу нь дунд болон түүнээс дээш хатуулагтай. Хөрсний чулуулаг нь орчин үеийн сэвсгэр хурдас болон шохойн чулууны жижиг судланцрууд агуулсан андезит, мета андезитаас бүрдэнэ. Бат бөхийн коэффициент проф. Протодеяконовын ангиллаар хөрсний чулуулагт $f=6-8$, шохойн чулуунд $f=8-10$ болно. Чулуулгийн хатуулгийн зэрэглэл нь өрөмдлөгөөр дунд болон хүнд ангилалд хамаарч байна. Иймээс уулын цулыг өрөмдлөг – тэсэлгээний аргаар урьдчилан сийрэгжүүлж уулын ажлыг явуулж ирсэн. Үндсэн чулуулгийг хучсан орчин үеийн сэвсгэр хурдсыг эксковатороор шууд утгаж ачна. Ашиглалтийн өмнөх жилүүдэд “Идэр Хайрхан” ХХК нь өөрийн өрмийн машинаар өрөмдлөгийн ажлыг зохион байгуулж, Харин 2017 оноос хойш тэсэлгээний ажлыг “Монмаг” ХХК- тай гэрээлэн гүйцэтгэж, 2024 онд үргэлжлүүлэн хамтран ажиллахаар төлөвлөөд байна. “Монмаг” ХХК нь тэсэлгээний ажил явуулах үед тэсрэх материалыг өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэн хүргэж, тэсэлгээний ажлыг зохион байгуулна. Тэсэлгээний ажлын үед “Монмаг” ХХК – ний мэргэшсэн тэсэлгээний баг уурхай дээрхи тэсэлгээний ажлыг зохион байгуулах бөгөөд тэсэлгээний ажлыг улиралд нэг удаа зохион байгуулдаг. Өрөмдлөг тэсэлгээний тооцоогоор 2024 онд нийт 65.4 мян.м³ уулын цул тэсэлж, нийт 3480 тууш м өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, 33 тн тэсрэх бодис хэрэглэхээр байна.

Хүснэгт 3. Өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцоо..

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
			Хөрс, Шохойн чулуу
			2024 онд
1	Чулуулгийн хатуулгийн коэффициент, Протодьяконовоор	-	8
2	Доголын өндөр, Н	м	10
3	Орлын өргөн, $A_{op}=R_y \cdot (\sin \omega_1 + \sin \omega_2)$	м	10
3	Улны бага эсэргүүцлийн шугам, W	м	3.4
4	Цооног хоорондын зай, $a = m \cdot W$	м	6.0
5	Цооногийн эгнээний тоо, n	ш	2
6	Эгнээ хоорондын зай, $b = a$	м	6.0
7	Цооногийн илүү өрөмдлөгийн гүн	м	0.9
8	Цооногийн гүн (илүү өрөмдлөгөтэй), L	м	10.9
9	Тэсрэх бодисын хувийн зарцуулалт, q	кг/м ³	0.5
10	1 м цооногт орох тэсрэх бодисын хэмжээ, p	кг	14.7
11	1 цооногт орох тэсрэх бодисын хэмжээ, $Q = q \cdot w \cdot a \cdot H$	кг	102.0
12	Цооногийн цэнэгийн урт, $L_c = L - L_t$	м	7.0
13	Цооногийн түгжээсийн урт, $L_t = (20-35) \cdot d_{цо}$	м	3.9
14	1м цооногоос гарах уулын цулын хэмжээ, $V = w \cdot a \cdot H / L$	м ³ /м	18.8
15	Жилд тэслэх уулын цулын хэмжээ	мян.м ³	65.42
16	Жилд хэрэглэх тэсрэх бодисын хэмжээ	тн	33
18	Жилийн өрөмдлөгийн хэмжээ	м	3480

Хүснэгтээс харахад 2024 онд ордоос хаягдал бохирдол тооцсоноор 70.0 мян.тн шохойн чулуу, 38.5 мян.м³ хөрс хуулах бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент 1.21 м³/тн болж байна.

Ашиглалтын систем

Ордыг ашиглах үүл – геологийн нөхцөл ба ашиглалтын систем. Цохиот толгой – 2 шохойн чулууны ордын хувьд хөрс хуулалт болон шохойн чулуу олборлох ажлыг өрөмдлөг тэсэлгээгээр урьдчилан сийрэгжүүлж эксковатор – автосамосвалын хослолоор буюу гадаад овоолготой тээвэртэй ашиглалтын системээр явуулна.

Уулын ажлын зохион байгуулалт. Уурхай 2024 оны 1 сараас 12 сарыг дуустал 12 сарын хугацаанд 10 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллана. Шимт хөрсийг утгуурт ачигч, автосамосвалаар хуулж шимт хөрсний овоолгын талбайд зөөж овоолно, хөрс хуулалтыг өрөмдлөг-тэсэлгээгээр урьдчилан сийрэгжүүлж, эксковатор– автосамосвалын хослолоор ухаж ачин, уурхайн зүүн урд талд байрлах хөрсний гадаад овоолгийн талбайд үргэлжлүүлэн овоолохоор төлөвлөж байна.

Ашиглалтын системийн параметрууд. Эксковаторуудын техникийн үзүүлэлтүүд болон шохойн чулуу, хөрсний чулуулгийн физик механикийн шинж чанаруудаас хамааруулан хөрс хуулалтын болон шохойн чулуу олборлолтын ажлын доголын өндрийг 5 метр байхаар тооцоолсон болно. Ашиглалтын системийн үндсэн хэмжигдэхүүнүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4. Ашиглалтын системийн үндсэн хэмжигдэхүүнүүд

№	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлт
1	Шохойн чулуу олборлолтын ажлын доголын өндөр	м	5 /10/
2	Хөрс хуулалтын ажлын доголын өндөр: • өнгөн хөрс хуулалтын үед • үндсэн хөрс хуулалтын үед /дэд догол/	м м	0.2-0.3 5
3	Шохойн чулуу олборлолтын ажлын доголын налуугийн өнцөг	град	60
4	Хөрс хуулалтын ажлын доголын налуугийн өнцөг: • ажлын • ерөнхий	град град	55-60 45-50
5	Экскаваторын оролын өргөн	м	12
6	Авто замын налуу	%о	60-80
7	Авто замын өргөн	м	8-10
8	Ажлын талбайн өргөн	м	20-25
9	Хөрс, хүдрийн доголын нурлын өргөн 2 эгнээгээр тэслэх үед	м	12.8
10	Овоолгын хамгийн их өндөр /8 м –ийн 2 давхар/	м	16
11	Овоолгын нийт хажуугийн налуу	град	22-35
12	Ил уурхайн жилийн хүчин чадал	мян.тн	70.0
13	Хоногийн хүчин чадал	тн	277
14	Ээлжийн хүчин чадал	тн	277

Уурхайн тээвэр

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 2024 онд 38.5 мян.м³ хөрс хуулж, 70.0 мян.тн шохойн чулуу олборлоно.

Хөрс тээвэрлэлт. Дөрөвдөгчийн хурдсыг эксковатораар шууд утган автосамосвалд ачиж үржил шимт хөрсний овоолгийн талбайд тээвэрлэнэ. Үндсэн чулуулгийг өрөмдлөг тэсэлгээний аргаар урьдчилан сийрэгжүүлсний дараа гадаад овоолгийн талбайд шилжүүлнэ. Хөрсний тээврийн зай дунджаар 400 м байна. Мөн дөрөвдөгч хурдаснаас үржил шимт хөрсийг хуулан уурхайн зүүн талд байрлах хуучин шимт хөрсний овоолгийн талбайд овоолно.

Шохойн чулуу тээвэрлэлт. Шохойн чулууг мөн өрөмдлөг тэсэлгээний аргаар урьдчилэн сийрэгжүүлсний дараа шохойн чулууны түр овоолго руу тээвэрлэх бөгөөд түр овоолгын талбай хүртэл тээврийн зай дунджаар 400 м байна. Уурхайн тээвэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн Howo маркийн автосамосвал ашигладаг бөгөөд шатахуун зарцуулалтаар бага, амьдрал дээр сэлбэг, үйлчилгээний зардлууд харьцангуй хямд, манай оронд өргөн хэрэглэдэг зэрэг олон давуу талтай.

2024 оны уурхайн гадаргуугийн ерөнхий төлөвлөгөө. Уурхайн гадаргуугийн байршлын ерөнхий төлөвлөлтийг ордын нөөц ашиглалтын хэтийн төлөв, ажиллагсадын ажиллах таатай орчин, эрүүл ахуйн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зэрэг нөхцөлүүдийг үндэслэн төлөвлөсөн.

Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай байлгахын тулд уурхайн гадаргуугийн барилга байгууламжууд нь авто замаар холбогдох бөгөөд замын хоёр талаар тоос шорооноос хамгаалж мод тарьж ургамалжуулж услаж байна.

Хүснэгт 5. Уурхайн гадаргуугийн байгууламж, эдэлбэр газрын хэмжээ

№	Эдэлбэр газрын нэр	Талбайн хэмжээ, га	Уурхайгаас алслагдсан зай, м
1	Уурхай	3.7	-
2	Хөрсний овоолго	3	80 /Зүүн урд/
3	Үржил шимт хөрсний овоолго	0.2	130 /Зүүн/
4	Ажилчдын байр, хоолны газар	0.1	130 / Урд зүгт/
5	Шохойн чулууны түр овоолго	0.08	180 /Зүүн урд/
6	Ангилах хэсэг	0.6	
7	Засварын газар, гараж	0.02	110 /Зүүн зүгт/
8	Автозам	0.9	-
Дүн		8.6	

1.5 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухай жилийн гол зорилт

Ордыг ил уурхайгаар ашиглах нөхцөлд ил уурхай, гадаад овоолго, үйлдвэрийн барилга байгууламж автозам, уурхайн тосгон зэрэгт зориулсан тодорхой хэмжээний газар шаардлагатай болно. 2024 оны эцсийн байдлаар уурхайн нийт эдэлбэрт 8.6 га талбайн гадаргуу өртөгдөж байна. Үүний 8 га талбай нь 2023 оны эцэст эвдрэлд орсон байсан бөгөөд энэ онд нэмж 0.6 га талбай уулын ажилд өртөж байна.

Эдэлбэр газруудыг зөв ашиглан байгаль орчныг унаган төрхөөр нь хадгалан хамгаалах ажлыг уурхай барьж байгуулах цагаас эхлэн хатуу хяналт тавьж ажиллах шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах болон эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зорилгоор 2024 онд дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

Үүнд:

- 1.5.1 Нийт уурхайг тойруулсан хашааг сэргээх, өмнөх онд шинээр мод суулгасан талбайг хашаажуулах, энэ онд төлөвлөж буй мод тарих талбайг мөн хашаажуулах.
- 1.5.2 Шатахуун, тослох материалаар хөрс бохирдуулахгүй ажилласан тос маслыг тоног төхөөрөмжийн тосолгоонд хэрэглэх, завсарын бүс, олборлолт, хөрс хуулалтын ажлын замын маршрутыг шинэчилж байнга засвар, арчилгааг хийж, автозам болон уурхайн траншейн зам ажлын тавцан мөргөцөгийн тоос, шороог багасгах зорилгоор услах зэрэг ажлуудыг хийнэ.
- 1.5.3 Хуурай хог, аюултай хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт тогтмол хаяж гэрээт байгууллагуудад ачуулан хамтран ажиллах.

- 1.5.4 Ахуйн бохир усны зориулалтын цэгийг гэрээт газраар соруулан савыг ариутган тогтмол цэвэрлэж байх.
- 1.5.5 Уурхайн ашиглалтын үед гал гарч болзошгүй хэсгүүдэд галын самбар байрлуулж, ил гал гаргах, тамхи татахыг хориглосон санамжуудыг тавих, мөн ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах.
- 1.5.6 Уурхайд тоос шороо босохоос сэргийлэх мөн эрүүл ахуйн таатай орчин бүрдүүлэх, ногоон байгууламж үүсгэх зорилгоор 2024 онд уурхайн засварын хэсгийн ойр орчмын 0.4 га талбайд замын усалгааг тогтмол хийх.
- 1.5.7 Уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа авто замын зогсоол, машин зам дагасан хэсэгт биологийн нөхөн сэргээлтийг хийх.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Уул зүй: Шохойн чулууны ордын талбай нь Хэнтийн уулархаг мужын баруун хойд салбар уулсуудын хүрээнд Хараа голын районд багтдаг. Газарзүйн байршлын хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсгийн дунд зэргийн уулархаг мужид хамаарагдах бөгөөд хамгийн өндөр цэг нь Их Нарст уул /1419.2 м/, хамгийн нам цэг нь Дархан хотын онгоцны буудал /710 м/ юм. Дундаж харьцангуй өндөр нь 300 – 400 м. Нийт нутаг нь өвс ургамлаар бүрэн бүрхэгдсэн, чулуулгийн гарш илэрц муу, харин уулын өмнөд хажуунууд чулуулгийн гарш илэрц сайтай, заримдаа бага хэмжээний нуранга, хад цохиотой байдаг.

2.2 Ус зүй: Талбайн хэмжээнд усан сүлжээ нилээд сайн хөгжсөн ба хамгийн том гол нь Хараа гол юм. Хараа голын усны өргөн 3 - 6 м, гүн нь 1.0 м - ээс хэтэрдэггүй. Талбайн төв хэсгээр нь Мухар, Хүйтний голууд урсдаг.

2.3 Уур амьсгал: Тус нутаг нь өвөлдөө бага зэргийн цастай хүйтэн, зундаа бороотой халуун байх ба эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын жилийн дундаж хэм -19°C-д хүрэх бөгөөд хамгийн хүйтэн 1-р сард -37°C болж, хамгийн дулаан нь 7-р сард 35°C-д хүрнэ. Жилд унах хур тунадас дунджаар 244 мм байдаг. Цас 10 - р сараас эхлэн 3 - р сар дуустал орох ба цасан бүрхүүлийн дундаж зузаан 0.5 м хүрнэ. Салхины чиглэл хойд талаасаа зонхилох ба дундажаар 3.5м/сек хурдтай боловч, 5-р сард 20-24 м/сек хүртэл шороон шуурга болдог.

2.4 Хөрс, ургамал: Нийт нутаг нь хөрс ургамлаар өтгөн хучигдсан бөгөөд Шарын голын зүүн талын хэсэг нь өтгөн нарсан болон хусан ойгоор хучигдсан, олон төрлийн цэцэгт ба өвслөг ургамлаар бүрэн бүрхэгдсэн, уулын ар хажууд нарс, хусан ой, багаар улиангар голын хөндийд бургас ховроор хус, нарс, улиас, зэрэг шилүүст ба навчит модлог ургамал ургадаг.

2.5 Амьтан: Ан амьтадаас буга, гөрөөс, чоно, баавгай, үнэг, хярс, дорго, тарвага, жигүүртэн амьтадаас тоодог, тогруу, ятуу, хүтүү амьдардаг бөгөөд гол горхины усанд загас, жараахай элбэг тохиолдоно.

2.6 Хүн ам, эдийн засаг: Судалгааны талбайн хүн ам нь газар тариалан мал аж ахуй эрхэлдэг, олон ястан үндэстний нутаг юм. Орд нь Дархан, Сэлэнгэ аймгийн Сайхан сумтай шороон замаар холбогдсон бөгөөд Дархан-Эрдэнэтийн чиглэлийн хатуу хучилттай замаас баруун зүгт 3 км зайд оршдог. Талбайн хэмжээнд орших томоохон суурин газар нь Дархан хот бөгөөд 200 гаруй км урт төмөр замаар, 220 гаруй км урт засмал замаар Улаанбаатар хотоос холбогдоно. Эдгээр суурин газруудад нүүрс олборлох уурхай, алт олборлох уурхай, ой модны аж ахуй, ахуй үйлчилгээний ба харилцаа холбооны салбар, эмнэлэг, 10-н жилийн дунд сургууль зэрэг үйлдвэр, үйлчилгээ, ахуйн соёлын төвүүд оршино. Нутгийн аль ч хэсэгт жилийн 4 - н улиралд автомашинаар явах бүрэн бололцоотой.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2024 онд уулын ажлын хөрс хуулалт, шохойн чулуу олборлолт, тээвэрлэлтийн үед 24,1 тн тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгох бөгөөд энэ жил нийт 15,03 тн хорт бодис ялгаруулахаар байна.

2024 онд ашиглах техникийн мэдээлэл :

1. Өрөм СБУ-100 1ш
2. Самосвал Хово-336 1ш
3. Экскаватор LS-290-7 1ш
4. Авто ачигч XGMA-951 1ш
5. Авто ачигч ZL-935 1ш

Дээрх тоног төхөөрөмж ажиллуулахад цагт 126 буюу нэг ээлжиндээ 1008л дизелийн түлш хэрэглэнэ. 2024 онд ялгаруулах нийт хорт хийн хэмжээ нь 23.2 тн байна.

Хүснэгт 6. Уурхайн тоног төхөөрөмжүүдийн түлшнээс ялгарах хорт хийн хэмжээ

№	Хорт хий, бодис	Нэгж ялгаруулалт, гр/л	Ялгаруулалтын хэмжээ, гр	
			1 хоног	207 хоногт/тн/
1	Нүүрстөрөгчийн исэл	20.6	20764.8	4.298313
2	Азотын давхар исэл	24.75	24948	5,164236
3	Нүүрстөрөгч	5.77	5816.16	1,203945
4	Хүхэрлэг хий	16.6	16732.8	3,463689
5	Хөө тортог	3.3	3326.4	0,688565
6	Хар тугалга	0	0	
7	Бензпирен	0.255	257.04	0,053207
8	Альдегид	0.74	745.92	0,154405
Нийт			72591.12	15,02636

Энэ жилд эвдрэлд орох талбайгаас үүсэх тоосжилтын хэмжээг тооцвол:

$$П = 55800 \text{ м}^2 \cdot 1.0 \cdot 10^{-6} \text{ кг/м}^2 \text{ сек}^{-1} \cdot 0.1 = 0.00558 \text{ кг/сек}$$
 буюу 20.088 кг/цаг, жилд (өдөрт 10 цаг жилд 120 хоног салхитай) үзэхэд 24.1тн тоосжилт жилд үүсэхээр байна.

3.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Унд ахуйн усан хангамжинд нийт 980 м³ ус хэрэглэхээр 2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан байна.

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментын дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2024 оны уулын ажлаар нийт 0.6 га талбай олборлолтонд өртөнө. Ордын уул геологийн тогтоцоос хамааран дотоод овоолго хийх боломжгүй тул гадаад овоолготой, тээвэртэй ашиглалтын системээр уулын ажлыг явуулж байна. Шимт хөрсний овоолгод 200 м³ хөрс байна.

Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно.

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэхь тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасана.

Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсч тоосжилт үүсгэх

Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй.

3.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтдууд дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүснэ.

БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт: Идэр хайрхан ХХК-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2020 онд “ТЕЭМ СМАЙЛ” ХХК-ийн боловсруулсан Цохио толгой 2 ордоос шохойн чулуу олборлох ловсруулах төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Хамрах хүрээ: Идэр хайрхан ХХК -ийн уурхайн MV-004658А ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа үндсэн олборлолтын үйл ажиллагаанаас гадна уурхайгаас гарах бусад чулуулгаар барилгын дүүргэгч материал дайрга үйлдвэрлэхтэй холбоотой төсөл ашиглалтын талбайн гадна хэрэгжсэн бөгөөд БОННУ-г холбогдох хууль, журмын дагуу БОАЖЯ-аар батлуулсан.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлээ болон компанийн дотоод бичиг баримт болох Агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүдрийн болон хаягдал чулуулгын овоолгууд, ил уурхай, тэсэлгээ, дулааны төв станц, түлшний хэрэглээ зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 7. 2024 онд Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажил

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн талбайд ашиглаж байгаа тээврийн хэрэгслээс үүсэх хорт хий агаарыг бохирдуулах, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоомжилт бий болох	250мөт/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийг тос, маслыг солиж байна.	Идэр хайрхан ХХК-ийн уурхайн талбайд	Мөт/цаг	100.000	Техникийн үйлчилгээ хийх хуваарийн дагуу	400.000	Улиралд	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай"хууль;MNS 4585:2016 "Агаарын чанар.Техникийн ерөнхийшаардлага"MNS 5885:2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ.Техникийн ерөнхий шаардлага"MNS ISO4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө"
2		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ, нэмж байршуулна.	Идэр хайрхан ХХК-ийн уурхайн талбайн дотоод зам,	Нэгж усалгаа	829,2	Тогтсон хуваарийн дагуу(Өвөл усалгаа багасна)	Үйл ажиллагааны зардалд орно	Жилийн турш	
3	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулах, хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Агаарын чанарын үзүүлэлтийг хянах	ДУА-ийн цаг уур орчны хяналт шинжилгээний газартай	Нэгж хяналт	80,000	Жилд 2 удаа 2 цэгт	160,000	Жилийн турш	"Агаарын тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар.
Нийт			560.000						

2024 онд уурхайн үйл ажиллагаанд байнга өртөх нийт 0.3 га зам ашиглагдана. Зам усалгаанд ус ашиглалтын нормоор 1 м²-т 0.3-0.4 л ус зарцуулна. Хараа голын сав газар газрын доорхи усны үнэ 2764. /Энэ үнэд ашиглалтын зориулалт тооцох итгэлцүүр, Экологи эдийн засгийн үнэлгээний хувь тооцоод 829.2 төг болж байна/

$$3000^2 * 0.4 \text{ л} = 1200 \text{ л} \text{ Усны үнэ} = 829.2 \text{ төг} * 1.2 \text{ м}^3 * 2 * 250 = 995040 \text{ төг}$$

5.2. Усан орчинд үзүүлж буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ

